



***Интернэтийн хурдыг
нэгдүүлэх хялбар арга***

Гарчиг

Рүүтэрээ зөв газар байрлуулах	1
Вирусны эсрэг програм уншуулах	1
Шинэчлэлтийг болиулах.....	2
Сурталчилгааг алга болгох.....	3
"Wi- Fi"-ийнхаа кодыг шалгах.	3

Рүүтэрээ зөв газар байрлуулах

Та рүүтэрээ хаана байрлуулдаг вэ? Арай доор байрлуулчихаад интернэт удаан байна гэдэг юм биш биз?



Wi Fi рүүтэр нь интернэтийн сигналыг агаараар дамжуулан түгээх үүрэгтэй байдаг. Та Wi Fi ашиглан интернэтэд ордог бол рүүтэрээ зөв байршуулах нь чухал. Учир нь рүүтэрээс цацагдаж буй интернэтийн долгион замдаа саадгүй нэвтэрч таны компьютерт очих ёстой. Ийи учраас та аль болох саад бага учрах өндөр газар байрлуулбал зохилтой.

Рүүтэрээ дээш тавих тусам интернэтийн хурд нэмэгдэж, таны асуудлыг шийдвэрлэх аж.

Мөн рүүтэрийг цахилгаан хэрэгслээс байнга хол тавьж байх хэрэгтэй. Зурагт, нөүтбүүк, утас зэрэг нь рүүтэрийн ажиллагааг доголдуулж болзошгүй.

Түүнчлэн интернэтийн хурданд таны ашиглаж буй рүүтэрийн өөрийнх нь цацах давтамж, хүчин чадал маш чухал нөлөөтэй байдаг. Тийм учраас та аль болох давтамж өндөртэй, сайн рүүтэр хэрэглэхийг зөвлөж байна.

Вирусны эсрэг програм уншуулах

Вирус нь компьютерийг гацааж, хурд удаашруулахаас гадна, интернэтийн хурдад ч мөн нөлөөлдөг. Иймд компьютертоо вирусны эсрэг програм суулгаж, долоо хоногт нэг удаа уншуулж байгаарай.



Шинэчлэлтийг болиулах

Компьютер нь формат хийсний дараа үйлдлийн системүүдийг шинэчилж, бидний хэлж сурснаар "update" хийдэг. Харин энэ үед интернэтийн хурд удааширдаг байна. Иймд та яг одоо хийх шаардлагагүй бол "update" хийхийг болиулж, асуудлаа шийдвэрлэж болох аж.



Сурталчилгааг алга болгох

Ямар нэгэн веб сайт руу ороход сурталчилгаа гарч ирж, төвөгтэй байдал үүсгэдэг. Энэ нь таны компьютерийн хурдыг ч давхар удаашруулж байдаг. Харин та үүнийг шийдвэрлэхийн тулд ашиглаж буй хөтөчдөө "Ad Block"-ийг суулгаарай. Энэ нь веб хуудсуудын сурталчилгааг блоклож, интернэтийн хурдыг нэмэгдүүлж ашиглахад хялбар болгодог.



"Wi- Fi"-ийнхаа кодыг шалгах

Хэрэв таны "Wi- Fi"-аар зэрэг 20 хүн орох юм бол, нэг секундэд 20 mb (мегабайт) хурдтай байсан интернэт 1 mb болон буурдаг байна. Иймд та "Wi- Fi"-ийнхаа кодыг шалгаж, өөр хэн нэгэн давхар орж байгаа эсэхийг олж мэдээрэй.



Анхаарал тависан та бүхэнд баярлалаа

***Мейжикнэт ХХК
Техникийн алба***